



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/59

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, Зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.5, 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөдэлгэр суманд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн “Цолмон зүрх” ХХК-д эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа эрхэлж буй “Хашцагаан сувд” ХХК-ийн шүдний үзлэг, оношилгоо, эмчилгээний үүдэн эмнэлэг, “Пиавка” ХХК-ийн уламжлалтын үүдэн эмнэлэг, “Гоё Сондор” ХХК-ийн лаборатори, Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа эрхэлж буй “Өргөжих үйлс” ХХК-ийн хүүхэд, дотор, уламжлалтын үүдэн эмнэлгүүдийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар тус, тус сунгасугай.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмийн бодлого, чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАШНАМЖИЛМАА

